Хургатай Хайрхан ХХК: Сонирхолоо илэрхийлэхийг урьж байна (EOI)

1. Урилга

Хургатай Хайрхан ХХК нь УБ хотод агуулах, тээвэр логистикийн цогц үйлчилгээ үзүүлэх чадвартай, тусгай зөвшөөрөл бүхий туршлагатай, шаардлага хангасан аж ахуй нэгж, компаниудыг Хамтран ажиллах сонирхолоо илэрхийлэх (EOI)-ийг урьж байна.

Энэхүү хамтран ажиллах сонирхол илэрхийлэх урилгын зорилго нь Улаанбаатар хотод байршилтай, компанийн ачаа барааг хүлээн авах, бүртгэх, хадгалах, төслийн талбай руу хүргэх үйлчилгээг цогцоор үзүүлэх чадвартай, бүх төрлийн ачаа барааг хүлээн авах хангалттай хэмжээний талбай, агуулах, тээвэрлэлтийн сүлжээг бий болгосон аж ахуй нэгж байгууллагуудийг тодорхойлоход оршино.

2. Ажлын хамрах хүрээ

Үүнд:

1) Бүх төрлийн ачаа барааг хүлээн авах задгай талбай болон дулаан агуулахтай байх;
2) Бараа материалыг компанийн өмнөөс хүлээн авч, бүртгэх, бүрэн бүтэн байдал болон аюулгүй байдлыг бүрэн хариуцах;
3) ERP системээр агуулах хоорондын шилжилт хөдөлгөөнийг хийж, захиалагч талын санхүү, хангамжийн нэгжтэй нягт хамтран ажиллах;
4) УБ хотод хүлээн авсан бараа материалыг хэсэгчлэн болон нэгтгэн, Хөвсгөл аймаг Цэцэрлэг сумын Овоотын уурхайн талбай руу хүргэх тээврийн сүлжээтэй байх;
5) УБ хотод бараа материал, эд хөрөнгийг хүлээн авснаас төслийн талбай хүртэлх бүрэн бүтэн байдал, аюулгүй байдал болон эд хөрөнгийн хариуцлагыг 100% хариуцан ажиллах;
6) Эд хөрөнгө, хариуцлагын даатгалд бүрэн хамрагдсан байх;

3. Үндсэн шаардлага

3.1 Агуулах/тээвэр логистикийн чиглэлээр хамгийн багадаа хоёроос доошгүй жил тогтвортой байнгын үйл ажиллагаа явуулсан байх;
3.2 Агуулах/тээвэр логистикийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, зөвшөөрлүүд нь хүчинтэй байх;
3.3 Эд хөрөнгө, хариуцлагын бүх төрлийн даатгалд хамрагдсан байх;
3.4 Мэргэшсэн, чадварлаг боловсон хүчинтэй байх;
3.5 Санхүүгийн чадвар, чадамжтай байх;
3.6 Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааг хангасан агуулах, тээврийн үйлчилгээ үзүүлдэг байх,

4. Ирүүлэх мэдээлэл

Сонирхсон компаниуд дараах мэдээлэл болон дэмжих баримт бичгийг ирүүлнэ:

1. Компанийн танилцуулга
2. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
3. Агуулах/тээвэр логистикийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл
4. Агуулахын хүчин чадал, дэлгэрэнгүй мэдээлэл,
5. Тээвэр логистикийн хүчин чадал, сүлжээний мэдээлэл
6. ХАБЭА, байгаль орчин, хөдөлмөрийн эрх болон нийлүүлэгчийн ёс зүйн шаардлагад нийцэх баримт бичиг
7. Холбогдох ISO болон бусад гэрчилгээний хуулбар
8. Санхүүгийн чадамж болон шаардлагатай даатгалын мэдээлэл
9. Ижил төстэй хийж гүйцэтгэсэн болон гэрээт ажлын мэдээлэл
10. Мэргэжлийн боловсон хүчний мэдээлэл

5. Үнэлгээ ба урьдчилсан шалгаруулалт

Урьдчилсан шалгаруулалтад тэнцсэн оролцогчдод дараагийн шатны ажлын даалгавар хүргэгдэх ба техникийн тодруулга уулзалтуудад урих болно.

6. Материал ирүүлэх заавар

Заалт	Заавар
Имэйлийн гарчиг	**УБ агуулах, тээврийн цогц үйлчилгээ үзүүлэх – [Компанийн нэр]**
Материал илгээх хаяг	**procurement@khurgataikhairkhan.mn**
Материал хүлээн авах эцсийн хугацаа	**2026 оны 10 сарын 30 өдөр, 17:00 цаг**
Тодруулга, лавлагаа	**procurement@khurgataikhairkhan.mn**

7. Анхааруулга

Энэхүү Сонирхол илэрхийлэх урилга (EOI) нь зөвхөн мэдээлэл цуглуулах болон боломжит нийлүүлэгч/гүйцэтгэгчдийг урьдчилан үнэлэх зорилготой бөгөөд ямар нэгэн үнийн санал хүлээн зөвшөөрсөн, гэрээ байгуулсан, захиалга өгсөн, ажил олгосон эсхүл цаашдын хамтын ажиллагааг баталгаажуулсан нөхцөл болохгүй.